



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ**

2020. оны 11. сарын 12. өдөр

Дугаар А/17.

Арвайхээр

Г Ковид-19 бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга  
хэмжээний тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны 11 дүгээр сарын 11-ны “Ковид-19 бэлэн байдал /хэсэгчлэн/-н зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ковид-19 бэлэн байдлын үед ажиллах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ковид-19 бэлэн байдлын үед байгууллагын дотоод удирдлагын программ хангамж, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг аудитор /П.Норпил/-т хариуцуулсугай.
3. Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг ажлын комиссын ахлагч Аудитын менежер /Д.Гансүх/-т үүрэг болгосугай.
4. Ковид-19 бэлэн байдлын үед ажилласан ажлын тайланг ҮАГ-ын Тамгын газарт долоо хоног бүрийн пүрэв гарагт тайлagnаж байхыг ажлын комиссын ахлагч Аудитын менежер /Д.Гансүх/-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЛАМААЧИН